



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль

Хөтөлбөрийн нэр: Уул уурхайн ашиглалтын технологи

Индекс: 072401 бакалаврын хөтөлбөр

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Баатархүү

Гишүүд: Б.Бат-Очир

Т.Цолмон

Он сар өдөр: 2022.10.20

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

БСШУСЯ-Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам

ШУТИС- Шинжлэх ухаан технологийн их сургууль

ГУУС- Геологи, уул уурхайн сургууль

УТС -Уурхайн технологийн салбар

ГТӨС- Газрын тос, өрөмдлөгийн салбар

ГГС- Геологи, гидрогеологийн салбар

ГС- Геодезийн салбар

ЭБИС- Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбар

УУАТ- Уул уурхайн ашиглалтын технологи

УУХҮЯ -Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам

ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ЭНБД- Эрдэмтэн нарийн бичгийн дарга

БХБ- Багшийн хөгжлийн баг

ҮЭ -Үйлдвэрчний эвлэл

МСҮТ- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

ХБНГУ- Холбооны бүгд найрамдах Герман улс

ТББ- Төрийн бус байгуулга

ОХУ- Оросын холбооны улс

ТИС -Техникийн их сургууль

БНХАУ- Бүгд найрамдах Хятад ард улс

ХУИС- Хүмүүнлэгийн ухааны их сургууль

АНУ- Америкийн нэгдсэн улс

БНСУ- Бүгд найрамдах Солонгос улс

НДШ- Нийгмийн даатгалын шимтгэл

НЗДХА- Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг

ЕБС -Ерөнхий боловсролын сургууль

ЭЕШ- Элсэлтийн ерөнхий шалгалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ШУТИС-ын Геологи, уул уурхайн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Уул уурхайн ашиглалтын технологи Mining technology	
Индекс	072401 бакалаврын хөтөлбөр	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Д.Баатархүү- Хөдөө аж ахуйн их сургуулийн Инженер, технологийн сургуулийн тэнхимийн эрхлэгч, доктор 2. Б.Бат-Очир – Монголын уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбооны гүйцэтгэх захирал, доктор 3. Т.Цолмон – Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн Уул уурхайн ашиглалтын технологи, инженер багш 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ахлах шинжээч Б.Мядагмаа	
Төлөвлөгөөний дагуу	Он сар өдөр	Хийгдсэн ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
		Шинжээчийн багийг томилох
		Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2022.09.28-10.06	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2022.10.08	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.10.11-12	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2022.10.20	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.11.07	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2022.11.12	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.11.15	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль нь “Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжлээр 1971 оноос анхны элсэлт авч сургалт явуулж эхэлсэн. Сургалт явуулж ирсэн 49 жилийн хугацаанд тухайн мэргэжлээр 1500 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн.

Уул уурхайн ашиглалтын технологи хөтөлбөр нь БМИҮЗ-өөр 2014 онд магадлан итгэмжлүүлсэн байна.

Сургалтын төлөвлөгөө кредитийн хуваарилалт

Хичээлийн төрөл	Заавал судлах хичээлийн		Сонгон судлах хичээлийн		Нийт судлах хичээлийн		
	кредит	хувь	кредит	хувь	кредит	хувь	
Ерөнхий суурь ба математик, суурь шинжлэх ухааны хичээлүүд /30%-аас ихгүй/	33	26	6	5	39	30	
Мэргэжлийн суурь хичээл /25%-аас ихгүй/	27	21	6	5	33	26	
Мэргэжлийн хичээл /45%-аас багагүй/	Хичээлүүд, төслүүд	39	30	9	7	48	37
	Дадлага	4	3	0	0	4	3
	Төгсөлтийн шалгалт/диплом	5	4	0	0	5	4
Нийт дүн	108	84	21	16	129	100	

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн хөтөлбөрийг 2014 оны БШУ-ны сайдын А/174 нийтлэг шаардлагын хүрээнд 10 бүлгээр боловсруулсан байна.
- ХБНГУ-ын Фрайбергийн Уул уурхайн академи Техникийн их сургуультай 3+2 хамтарсан хөтөлбөртэй уялдуулах, хөтөлбөрт оролцогч талуудын судалгааны дүнд үндэслэн ерөнхий суурь хичээлд Мэргэжлийн удиртгал, Харилцааны англи хэл, Мэдээллийн технологийн хэрэглээ I,II хичээлүүд заавал судлахаар, мэргэжлийн суурь хичээлд Инженерийн механик, Магадлалын онол, математик статистик, Шинжлэх ухаан, технологийн англи хэл хичээлүүд заавал судлахаар, Ердийн дифференциал тэгшитгэл, Дулаан техник, термодинамик, Гидравлик хичээлүүд сонгоноор, мэргэжлийн хичээлд Уурхайн хаалт, нөхөн сэргээлт, Уурхайн хажуугийн тогтворжилт хичээлүүд заавлаар, бакалаврын дипломын ажлыг сайжруулах үүднээс Уурхайн төсөл, төлөвлөлт хичээл заавлаар сургалтын төлөвлөгөөнд шинээр оруулж батлуулан хичээлүүдийн хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлсэн байна.

- Засгийн газрын 2012 оны 1-р сарын 18-ны өдрийн 19-р тогтоолоор Монгол Улсад эрэлт ихтэй мэргэжлийн 9-д “Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжил бичигдсэнээс хойш тогтмол тус жагсаалтад багтсан байна.
- 2019 оны хөдөлмөрийн зах зээрийн эрэлтийн барометрийн судалгаагаар тус салбарт ажиллах хүчний 2200 хүний эрэлт хэрэгцээ байгаа нь тогтоодсон байна.
- Австралийн Кюэнслэндийн их сургууль, Канадын Бритиш Колумбын Их сургууль, Колородагийн Уул уурхайн сургууль, Английн Камборны Уул уурхайн сургуулиудын 4 хөтөлбөртэй харьцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Монгол улсад эрэлт хэрэгцээтэй мэргэжлийн жагсаалтад “Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжил орсноос хойш тогтмол тус жагсаалтад бичигдэж байна.
- ХБНГУ-ын Фрайбергийн Уул уурхайн академийн Техникийн их сургуультай хамтарсан хөтөлбөрөөр суралцагчид нь “Уул уурхайн ашиглалтын технологи” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний дагуу эхний 3 жил ГУУС-д суралцах ба цуглуулсан кредит нь шууд тооцогдон суралцах сургуульд гэрээний дагуу 4-р ангиасаа үргэлжлүүлэн суралцагаараа давуу талтай байна.

Зөвлөмж:

- Тайланд тусгаж харьцуулсан судалгаа хийсэн гадаадын нэр хүнд бүхий 4 улсын сургалтын төлөвлөгөөнд нэгэн зэрэг байгаа зарим ур чадвар олгох хичээлүүд уул уурхайн ашиглалтын технологи мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд байхгүй байгааг анхаарч, сайжруулах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилго нь бүрэлдэхүүн сургууль, их сургуулийн эрхэм зорилго, зорилтуудыг дэмжсэн, харилцан уялдаатай гаргасан байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо салбарын эрхлэгч, профессор, багш нар, мэргэжлээр суралцагч оюутнууд, төгсөгчид, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагууд /төрийн болон хувийн хэвшил/-д зэрэг хөтөлбөрт оролцогч талуудаас судалгаа авч тодорхойлсон байна.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт болон сургалтын зорилго, зорилтуудын хоорондын уялдаа, холбоог 1 дүгээр хүснэгтэд тодорхой тусгаж өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- 1971 оноос мэргэжлээр элсэлт авч эхэлснээс хойш Монгол Улсын Боловсролын системд орсон өөрчлөлт, шинэчлэлт түүнчлэн ШУТИС-д анхлан нэвтэрсэн кредит систем мөн уул уурхайн техник технологийн хөгжил, зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагыг үндэслэн сургалтын хөтөлбөрт 9 удаа өөрчлөлт оруулсан байна.
- Сургалтын төлөвлөгөө нь ерөнхий суурь 39 кр, мэргэжлийн суурь 33 кр, мэргэжлийн хичээл, дадлага, дипломын ажил 57 кр, нийт 129 кр цаг судлахаас заавал судлах 108 кр, сонгон судлах 21 кр үзэхээр төлөвлөсөн байна.
- Ерөнхий суурь хичээл хэсгийн агуулга нь заавал судлах 33 кр, сонгон судлах 6 кр цаг байхаар төлөвлөж, нийт крдедит цагийн 30% байхаар тусгаж өгсөн байна.
- Мэргэжлийн суурь хичээл хэсгийн агуулга нь заавал судлах 27 кр, сонгон судлах 6кр цаг байхаар төлөвлөж нийт крдедит цагийн 26% байхаар тусгаж өгсөн байна.
- Харин мэргэшүүлэх хэсгийн агуулга нь заавал судлах хичээл 39 кр, сонгон судлах хичээл 9кр цаг, дадлага 4 кр цаг, төгсөлтийн ажил 5 кр цаг байхаар төлөвлөж нийт крдедит цагийн 44% байхаар баталсан байна.
- Сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөрөөр суралцах 4 жилийн хугацаанд үзэх хичээлүүдийн өмнөх холбоо, судлах улирлыг тусгаж өгсөн мөн оюутанд санал болгож улиралд үзэх хичээлүүдээр гаргасан байна.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан зураглал гаргасан байна.
- Хичээлийн хөтөлбөрт улирал, хичээлийн задаргаа, багшийн мэдээлэл, сурах бичиг, өмнөх холбоо, зорилго, үнэлэх хэлбэр, эзэмших мэдлэг, ур чадвар ба хичээлийн агуулгын хамаарал, орох төлөвлөгөө, сэдэв багтсан байна.
- Хичээлийн хөтөлбөрт дараах мэдээллүүд байна. Үүнд.
 1. Хичээлийн ерөнхий мэдээлэл /нэр, код, кредит, тодорхойлолт, өмнөх холбоо, задаргаа, зорилго, суралцахуйн үр дүн/
 2. Хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн хамаарал
 3. Сургалт явуулах хэлбэр
 4. Суралцахуйн үнэлгээ, хувь жин /рубрик/
 5. Бие даалтын ерөнхий удирдамж, үнэлгээний арга
 6. Хичээлийн төлөвлөгөөнд хичээлийн сэдэв, хичээлийн суралцахуйн үр дүнгийн хамаарал, хичээлийн хэлбэр, заах аргазүйд лекцийн хичээлийг харилцан яриа бүхий интерактив аргаар, семнарын хичээлийг тонгоруу аргаар заахаар тусгаж өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалт 2014 оны БШУ-ны сайдын А/174 нийтлэг шаардлагад зааснаас мэргэжлийн суурь хичээлийн кредит их, мэргэшүүлэх хичээлийн кредит бага байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн дадлагын тоо, кредитийн хэмжээг нэмэгдүүлж зураг төсөл, ил уурхай, далд уурхай гэсэн чиглэлтэй болгох.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, чадамжид суурилсан, арга зүй нь хөгжин сайжирч байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших мэргэжлийг эзэмших чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тодорхой хэмжээнд хөгждөг байдлаар явагдаж байна.

Илрэл нотолгоо:

- Хичээл хоорондын уялдаа холбоог нягт гарган графикаар харуулж, нэгж хичээл тус бүрийн суралцахуйн үр дүн суралцагчдад олгох мэргэжлийн мэдлэг, ур чадвар, харилцааны ур чадвар, асуудлын шийдвэрлэх чадвар, тунгаан цэгнэх чадвар, инженерийн ёс зүйтэй холбогдож хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхд чиглэсэн байна.
- Хичээлийн кредитийн хуваарилалт нь 3 кредит үед долоо хоногт орох цаг нь лекц 2 цаг, семинар, лаборатори 2 цаг, бие даалт 5 цаг байхаар хувиарлагдаж, 1 улиралд 14-19 кредит үзэхээр төлөвлөгдсөн байна.
- Нэгдсэн системээр багш, оюутнууд холбогдон сургалтын процесс, дүгнэх бүх үзүүлэлт, санал гомдол, багшийн үнэлгээг гарган ажиллаж байна.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу улирал, долоо хоногийн төлөвлөгөө гарган, түүнээ дүгнэн ажиллаж байна.
- Дадлагын ажлыг компаниудтай гэрээ байгуулан хийж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хичээлийн төлөвлөлт, уялдааг нарийвчлан гарган ажиллаж байна

Анхаарах асуудал:

- Далд уурхайн ашиглалт технологийн цагийг нэмэгдүүлэх
- Геотехнологийн шинэ ашиглалтын аргын хичээл нэмэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглан ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөрийн профессор, багш нар CDIO сургалтад 2 удаа хамрагдан хөтөлбөрийн сургалтын арга зүйгээ хөгжүүлэх, сургалтын идэвхтэй аргуудыг заалгасан, Оюу толгой ХХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Оюу толгой ХХК-ийн уурхайн сургалтын хэлтэст 2019 оны 11 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд таван багш нар онол, практикийн сургалтад хамрагдаж, онол ба практик хослуулан сургалтын агуулгыг шинэчлэх талаар суралцсан байна.
- ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвөөс зохион байгуулсан “Дижитал контент бэлтгэх, онлайн сургалтыг үр дүнтэй зохион байгуулах нь” сэдэвтэй онлайн сургалтад хамрагдаж багш нар хамрагдаж е-контентийн хичээлээ бэлтгэж байна.
- Одоо лекцийн хичээлийг интерактив аргаар, семинарын хичээлийг тонгоруу сургалтын аргаар явуулж, зарим мэргэжлийн хичээлийн онцлогоос хамаарч семинарын хичээлийг практик жишээ, видеогоор харуулах, ярилцах байдлаар явуулж байна.
- ШУТИС-ийн Багшийн хөгжлийн төвтэй хамтран сургалтын заах арга зүй, төлөвшил, ёс зүй, хариуцлага болон бусад чадварыг хөгжүүлж ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хичээлийн е-контент хичээлийн тоог нэмэгдүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйг бий болгож байгаа ба энэ арга зүйгээ сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын үнэлгээг ШУТИС-ын оюутны сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу багшийн 70 оноо ба эцсийн шалгалтын 30 оноог ашиглаж байгаа ба шууд дагуу үнэлэхдээ бакалавр оюутны мэдлэг, чадвар, төлөвшлийг хоёр үе шаттайгаар үнэлэх ба явцын үнэлгээ буюу багшийн 70 хүртэл оноо, эцсийн үнэлгээ буюу жинхэнэ мэдлэгийн түвшнийг улирлын шалгалтын 30 хүртэл оноогоор үнэлж байна.
- Сургалтын үнэлгээний үр дүнг шууд үнэлгээний аргаар үнэлдэг.
- Суралцагчийн үнэлгээг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулан гаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцахуйн үнэлгээнд үнэлгээний даалгавар, дүгнэх шалгуур үзүүлэлт, хугацаа, онооны эзлэх хувь, хамаарах суралцахуйн үр дүнг тусгаж, бие даалтын үнэлгээний рубрикийг тодорхой гарган оруулж өгсөн байна.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, компьютерын тусгай дадлагын ангиуд, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн, шинэчлэл хийгддэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөр нь нийт сургалтын өрөө, анги танхимт 17, үүнд: хичээлийн өрөө, лекцийн танхим 7, лаборатори болон компьютерын өрөө 4, багш нарын өрөө 6 байна. Үйлчилгээнд зориулсан номын сан, урлаг заал, спорт заал, дотуур байр, цайны газар, оюутны үйлчилгээний газрууд, өлгүүр, ариун цэврийн өрөө нийт 10 гаруй байна.

Нийт сургалтын өрөөнүүд стандарт талбайн норм шалгууруудыг хангасан, өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, нэг оюутанд ногдох талбай хичээлийн анги танхимуудад 1.1-1,3 байна. Нэг багшид ногдох талбайн норм 4 м² байхаас 4,9 м² байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Лаборатори болон тусгай зориулалтын программ хангамж бүхий танхимуудыг аж ахуйн нэгжүүдийн дэмжлэгийг түлхүү ашиглан байгуулсан нь туршлага болгох боломжтой.

Анхаарах асуудал:

- Танхимуудыг хичээлийн бус цагаар ашиглах цагийг нэмэгдүүлэх, утас, компьютер цэнэглэх газруудыг олшруулах шаардлагатай.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүнд ширээ, сандал, шүүгээ, компьютер, тусгай дэлгэц, самбар зэрэг нь нэг өрөөний суудлын тоонд харьцуулахад нэлээд хангагдсан байна.
- Уул уурхайн зураг зүйгээр компьютер, программ хангамжид суурилсан тус бүр 28 суудалтай 2 лаборатори, мөн чулуулгийн физик, буталлын 12 суудалтай 1, уурхайн технологи, программчилсан төслийн 30 суудалтай лабораториуд байна.
- Программчилсан төслийн лабораторид нийт 30 суурин компьютерыг сургалтад зориулсан уурхайн төлөвлөлтийн Micromine, Datamine, HxGN Mineplan, мөн геотехникийн Phase 2, Plaxis 3D Input, тээврийн SOLIDWORKS, агааржуулалтын Ventsim Lite программ хангамжуудаар тоноглон ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Лабораторийн хичээлүүдэд Ил уурхайн процесс I ба II, Ил уурхайн ашиглалтын технологи I, Уурхайн хажуугийн тогтворжилт, Уурхайн төсөл, төлөвлөлт хичээлүүдийг программ бүхий компьютерын танхимуудыг ашиглаж байгаа нь сайшаалттай.

Анхаарах асуудал:

- Тусгай лаборатори, компьютерийн танхимуудад суралцагчдыг чөлөөт цагаараа тухайн танхим, лабораторийг судалгаа, шинжилгээний чиглэлээр ашиглах боломжийг нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Далд уурхайн процесс, Далд уурхайн ашиглалтын технологи, Орд газрыг далд аргаар нээх гэсэн хичээлүүдийн лабораторийн болон компьютер загварчлалын чиглэлээр нэмэлт цагаар оюутнууд сууж ажиллах нөхцлийг бүрдүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сангийн эх үүсвэр номын фонд болох сурах бичиг, эрдэм шинжилгээний сэтгүүл, гарын авлага зэргийн баяжилт сайн байна. Тухайн хөтөлбөрт ашиглах боломжтой номын фондыг хэлээр ангилахад монгол 6152, орос 4100, англи 20, нийт 10272 номтой байна. Мөн магистрын 144, докторын 25 ажлыг номын санд танилцах боломжтой байна.
- Мөн тухайн хөтөлбөрт ашиглах боломжтой Монголын 3, ОХУ-ын 4 мэргэжлийн сэтгүүлүүдийн 2000-2019 оны дугааруудтай уншиж танилцах боломжтой байна.
- Номын сангийн уншлагын 80-200 хүртэл суудалтай 8 танхимаар үйлчилж ба хичээлийн байр болон номын сан дахь утасгүй интернэтийн сүлжээг ашиглан шаардлагатай мэдээллийг суралцагчид авах боломжтой байна.
- Мөн тогтмол хэвлэлүүдтэй танилцах боломжоор хангагдсан. Мөн дэлхийд тэргүүлэх шинжлэх ухааны сэтгүүл, ном сурах бичгийн онлайн фондод ШУТИС-аас нэвтрэх, татаж авах боломжоор хангагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан дурын мэдээллийг номын сангаас болон цахимаар орж танилцах боломжтой байна.

Анхаарах асуудал:

- Англи хэл дээр мэргэжлийн нэр томьёо, технологийн зааврын мэдээллийг түлхүү бий болгох

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- “Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж ГУУС-ын Уул уурхайн технологийн салбарт харьяалагдах ба 16 багш ба 2 ажилтантай баг байна.
- 16 багш уул уурхайн 18 чиглэлийн хичээлийг давхардсан болон дагнасан хэлбэрээр хариуцан заадаг байна. Энэ багш нарыг сэлгүүлэн ажиллуулах багшийн хангамжийг илүү хүртээмжтэй, сонголт хийх илүү боломжийг бүрдүүлж байна.
- Багийн багш, ажилтан бүр жил улирлын төлөвлөгөөг боловсруулан ажилладаг ба тайланг мөн гаргаж салбарын нэгдсэн тайланд тусгуулан ажилладаг байна.
- Хичээлийн зорилго, сургалтын материалын хүртээмж, лекц семинарын уялдаа болон багшийн соёл, үнэлгээний бодит байдал зэрэг 9 асуултаар хичээл орсон оюутнуудаас судалгаа авахад 4.7 буюу маш их сэтгэл хангалуун гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа, түүний мэдээлэл болон санал, гомдлыг UNIMS системээр багш, суралцагчид тогтмол ашиглан хэвшсэн байна.
- Удирдлагын мэдээллийн системийг онлайн болгосон нь сургуулийн бодлогыг тухайн хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулах, сургалтын 7 хоног бүрийн төлөвлөлтийн хэрэгжилтийг бүрэн хянах боломжийг бий болгосон байна.
- Мэдээллийн систем нь оюутны сургалтын төлөвлөлтийг чанаржуулахаас гадна санал, шүүмжлэл гаргах ил тод байдлыг хангахад илүү нээлттэй болгосон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарыг хөтөлбөрийн хичээлүүд дээр сэлгэн ажиллуулах боломж бүрдсэн ба суралцагч нарт сонголт хийх давуу талтай байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Нийт 7 орны 9 их дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

- ХБНГУ–ын Фрейбергийн Техникийн Их Сургуулийн Уул Уурхайн Академитай хамтран оюутан солилцон суралцуулах “3+2” хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж 10 оюутан Германд суралцаж, 3 оюутан Улаанбаатар хотод ирж дадлага хийсэн байна.
- Хамтарсан хөтөлбөрөөр нийт 10 оюутан гадаадын сургуулиудад үргэлжлүүлэн сурч байгаа ба 10 оюутныг ОХУ-ын уурхайнуудад дадлага хийлгэсэн байна.
- ОХУ-ын Чита хотын Уул уурхайн дээд сургуульд 10 оюутан хоёр ил уурхайд дадлага хийсэн харин Японоос 8 оюутан ирж танилцах дадлага хийсэн, 2018 онд ОХУ–ын Москва хотын Уул уурхайн их сургуульд УУАТ-ийн 3 оюутан уул уурхайн мэргэжлээр сурч буй оюутнуудын дунд зохиогдсон Олон улсын олимпиадад идэвхтэй оролцон тусгай байрын шагнал авсан нь идэвхтэй хамтын ажиллагаатай байна.
- Хамтын ажиллагааны гэрээтэй сургуулиудад 3 багш докторын зэрэг хамгаалж, 15 багшаа төрөл бүрийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх гадаадын сургалтад хамруулсан нь хөтөлбөрийн чанарыг дээшлүүлэхэд ач холбогдолтой болсон байна.
- Төгсөгчидтэй хамтран санаачлан явуулж буй проф.Я.Гомбосүрэн болон Б.Ишмэндийн нэрэмжит Эрдэм шинжилгээний хурал тогтмолжсон ба жил бүр хавар намар зохион байгуулагдан, илтгэлээр товхимол гаргаж байна.
- Төгсөгчдийг давтан сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тэсэлгээний сургалтыг 2 жил тутамд мэргэшсэн ба зөвлөх инженерийн сургалтуудыг жил бүр тогтмол хийж хэвшсэн байна..

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадын ижил мэргэжлийн сургуулиудтай идэвхитэй хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрт гадаад оюутнууд ирж суралцахад анхаарах

Зөвлөмж:

- Хамтын ажиллагаатай сургуулиудтай хамтарсан хөтөлбөрөөр суралцах оюутны тоог эрс нэмэгдүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн төсөв, түүний зарцуулалт салбар сургуулийн нэгдсэн төсвөөр хэрэгждэг.
- Нэг оюутанд ногдох орлого зарлагын харьцаа 1:1 байна.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагдах хувь хэмжээ тогтвортой байна.
- Сургуулийн төсвийн орлогын дийлэнхийг тухайн хөтөлбөрөөр суралцагчдын төлбөрөөс оруулж байна.
- Оюутолгой ХХК, Эрдэнэс таван толгой ХХК, Эрдэнэт үйлдвэр, Төрийн өмчит үйлчилгээний газар, Эра Бласт ХХК, Цайрт минерал ХХК, Хас банк, Степ Голд ХХК,

Зориг сан болон Дэлхийн зөн байгууллагууд оюутны тэтгэлэг, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллаж байна.

- Гадаадын тэтгэлэг, сургалтын төлбөрийн санхүүжилтийн тайланг нарийн чанд гаргаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Уул уурхайн томоохон компаниудын захиалгаар мэргэжилтэн бэлтгэх, ажилчдыг мэргэжил дээшлүүлэх зориулалтаар хамтарсан хөтөлбөр боловсруулан сургалт явуулж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөт ажлыг ШУТИС-аас нэгдсэн журмаар зохион байгуулж мөрддөг ба хэрэгжүүлэгч баг гарган үйл ажиллагааг явуулдаг нь ирээдүйн мэргэжлээ сонгох гэж байгаа сурагчдад болмжийг олгож өгдөг давуу талтай байна.
- ШУТИС-ТУР танилцуулах аяллыг зарим ерөнхий боловсролын сургуулиудад явуулсан ба мэргэжил сурталчлах ажлыг тусгай хөтөлбөрөөр явуулж сурагчдыг сургуультайгаа танилцуулах ажил зохиосон байна.
- 2020 оны хаврын улирлаас TV6 HD сувгийн “ЭКО” танин мэдэхүйн теле хичээлийн цагаар “Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжлийн тухай мэдээллийг багш Б.Улаанбаатар тодорхой давтамжтайгаар явуулж сурталчилж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ерөнхий боловсролын сургуулиудад танилцуулга хийдэг

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн сурталчилгааг төрөл бүрээр нэмэгдүүлэх шаардлагатай

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

ШУТИС-ийн вэйб сайтаас тусад нь ГУУС-ын сайтад мэдээллийг тогтмол оруулж шинэчлэн ажиллаж байгаа болон багш болон оюутны хооронд UNIMIS системээр хичээлийн файл, дүн оруулах, санал хүсэлт авах, багш нарыг үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулдаг нь давуу талыг харуулж байна. Үүнд:

- Нүүр хуудас:Цахим сургалт
- Хичээлийн мэдээлэл:Цахим сургалт-Хичээл-Удирдамж
- Хичээл багшийн мэдээлэл:Хичээл зааж байгаа багшийн мэдээлэл харах
- Хичээлийн мэдээлэл:Цахим сургалт-Идэвхтэй улирал
- Оюутанууд цахим сургалт:Хичээл орж байгаа багштайгаа холбогдох
- Хичээлийн файл цэс: Хичээл үзэх бол дарах.
- Зар мэдээ:Энэ хэсэгт багшийн хичээлтэй холбоотой оруулсан зарлал харагдана.
- Бие даалт:Бие даалт өгсөн хичээлийн код харагдана.
- Нэмэлт даалгвар: Нэмэлт даалгварын цэст зайн сургалтын системээр багшаас оюутануудад илгээгээгүй даалгвараас бусад даалгварыг илгээнэ гэх зэргээр цахим бүртгэлээр бүх хичээл сургалыг хийж гүйцэтгэх давуу тал бий болгон хэрэгжүүлсэн нь харгадаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн танилцуулгыг олон нийтэд цахимаар сурталчлан түгээх боломжийг бий болгоход анхаарах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн шалгуур үзүүлэлтийг хангасан хүсэлт гаргагчид тухайн хөтөлбөрөөр суралцаж байна. Хэрэглэж байгаа элсэлтийн журам шаардлагыг хангаж байна.
- Сүүлийн 5 жилд хөтөлбөрөөр суралцагчдын тоо тогтвортой өссөн байгаа нь элсэлтийн бодлого үр дүнтэй байгааг харуулж байна.
- Хөтөлбөрийн мэргэжлүүдээр элсэгчдийн ЭЕШ-ын онооны дундаж сүүлийн 4 жилд 520-иос дээш байгаа нь хангалттай үзүүлэлттэй байна.
- Шинэ элсэгчдэд гарын авлага цахимаар өгдөг ба үүнд бүх шаардлагатай мэдээлэл, сургалтын хөтөлбөр, дүрэм журмууд орсон байна.
- Суралцагчдад зориулсан 4 журам мөрдөгдөж байна. Энд ёс зүйн дүрэм зэрэг ач холбогдолтой журмууд орсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр элсэгчид сүүлийн 4 жилд хяналтын тоондоо хүрэхгүй байгааг анхаарч тус мэргэжлийг түлхүү сурталчлан сонгох сонирхлыг элсэгчдэд бий болгох

Зөвлөмж:

- Уул уурхайн ашиглалтын технологи мэргэжлээр төгсөгчдийн эрэлт хэрэгцээ их байгаатай уялдуулж элсэгчдийн тоог нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх үйлчилгээг шинээр элссэн оюутанд зөвлөх багш хичээл орсноор хэрэгжүүлж байна.
- Элсэгчдийн суралцах бүх хөтөлбөр, дүрэм журам, заавар батлагдсан байдлаар цахимаар олгогдож байна.
- Мэргэжлийн удиртгал хичээлийг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн нь оюутныг хөтөлбөрт зөв чиглүүлэхэд үр дүнгээ өгч байна.
- Хөтөлбөрийн хүрээнд жил бүр 4 төрлийн ЭШ-ний хурал явуулж байгаагийн 1 нь хавар бүр оюутнуудын дунд явуулж буй Б.Ишмэндийн нэрэмжит хурал бөгөөд энэ хурлын товхимолыг цаасаар болон цахимаар гарган нийтэд танилцуулж байгаа ба тэргүүн байруудыг ШУТИС-ийн нэгдсэн шалгаруулалтад оролцуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Суралцах арга, ирээдүйн ажил мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг төгсөгчид ба сайн сурдаг оюутнуудтай уулзуулах уулзалт, ярилцлагыг жил бүр төлөвлөн зохион байгуулах

Зөвлөмж:

- Оюутны эрдэм шинжилгээний хурлын оролцоо, идэвхийг улам нэмэгдүүлэх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулиас болон олон нийтийн байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнүүдэд оюутнууд идэвхтэй оролцож байна.
- 2019 оноос 2022 он хүртэл Захирлын нэрэмжит хуудасд сурлага, урлаг, спорт, олимпиад, олон нийтийн арга хэмжээнд идэвхи зүтгэл, амжилт гаргасан 87 оюутан бичигдэж 134.25 кредитийн төлбөрөөс чөлөөлөгдсөн байгаа нь тэдэнд санхүүгийн бодитой дэмжлэг болсон.
- Нийт суралцагчдаас сүүлийн 5 жилийн байдлаар харвал жилд 11-32 оюутан тэтгэлэгт хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт зарим суралцагчид компанийн гэрээгээр тэтгэлэг авсан байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдын олон нийтийн сайн дурын ажлын оролцоог бүртгэлжүүлэн урамшуулах, үнэлгээ өгөхөд анхаарах

Зөвлөмж:

- Компаниудын гэрээгээр тэтгэлэгт хөтөлбөрт суралцагчдыг хамруулдаг туршлага дээрээ тулгуурлан тэтгэлэгээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шилжилт , хөдөлгөөний дүрмийг Ректорын 2014 оны А64 болон 2015 оны А188 тушаалуудаар гаргасан журмаар зохицуулдаг байна.
- Оюутны шилжилт хөдөлгөөн нэлээд гардаг сүүлийн 4 жилийн байдлаар 67 оюутан өөр хөтөлбөрт шилжин, харин тус хөтөлбөрт Эрдэнэт, Дархан зэрэг ижил мэргэжлийн сургуулиас 89 оюутан шилжин ирсэн нь суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шилжилт хөдөлгөөний чөлөөтэй шийддэг байгаа нь харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Анхаарах асуудал:**

- Шилжилт хөдөлгөөнд жил бүр нарийвчилсан дүгнэлт хийх.

Зөвлөмж:

Шилжих шалтгааныг судлан багасгах боломжийн талаар арга хэмжээ төлөвлөн ажиллах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичиг зааврыг мөн Ректорын 2014 оны А64 тушаалаар гаргасан баримт бичгийн загвар, заавраар бусад хөтөлбөрүүдийн адилаар амжилттай хэрэгжүүлж байна.
- 3,6-аас дээш үнэлгээтэй төгсөгчдөд “Онцлох” диплом олгож байгаа ба 2022 онд 41 төгсөгчөөс 1 онцлох дипломтой төгсөгч, сүүлийн 4 жил 6 онцлох дипломтой төгсөгч гарсан байна.
- Мэргэжлийн индексийг төгсөгчдөд 2014 оноос хойш D072401 гэсэн “Уул уурхайн ашиглалтын технологи” гэсэн индексээр олгож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Уул уурхайн технологийг хэрэгжүүлэгч үндсэн 15 багшийн хувьд:
Боловсролын зэрэг: магистр 8, доктор 6, шинжлэх ухааны доктор 1
Албан тушаал: багш 6, ахлах багш 5, дэд профессор 2, профессор 2
Ажилласан жил: 6-10 жил ажилласан 6, 11-15 жил ажилласан 2, 16-20 жил ажилласан 3, 21-25 жил ажилласан 4 хүн байна.
Нас: 31-40 насны 10, 41-50 насны 3, 50 дээш насны 2 хүн байна.
Эндээс харвал хөтөлбөрийн багш нарын 46,6% доктор, 26,6% профессор, 6-н жилээс дээш жил ажилласан байгаа нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай дадлага, мэргэжлийн туршлагатай гэж үзэж болохоор байна.
- Шаардлагатай багшийн захиалгыг баг тэнхимээс гаргаж, бүрэлдэхүүн сургуулиар хэлэлцүүлж, сургалтын бодлого зохицуулалтын албаар хянуулж Ректорын ажлын албанд ирүүлснээр багш сонгон шалгаруулах ажлын хэсэг ярилцлага хийж, 3 чиглэлээр шалгалт авдаг байна.
- Нэг багшид ноогдох заах хичээлийн тоо дунджаар 2 бөгөөд нэг багшид ноогдох оюутны тоо 2018 онд 27,6 оюутан, 2019 онд 27,8 оюутан, 2020 онд 24.6 оюутан тус тус ноогдож байна.
- ШУТИС-ийн багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журмыг ШУТИС-ийн захирлын 2019 оны 5-р сарын А/113 тоот тушаалаар баталж, мөрдлөг болгон ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Шинэ төгсөгчид шууд ажлын байран дээр гарахад давтан сургаж ажиллуулах тохиолдлууд их байгааг анхаарч, үйлдвэрлэл уурхай дээр 5-с доошгүй жил ажилласан инженерийг багшийн сонгон шалгаруулалтад оруулж авах, мөн ажиллаж байгаа багш нараа 2-3 жилээр үйлдвэрлэл дээр ажиллуулж багшлуулах.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС нь Багшийн хөгжлийн төвийг 2015 оны 11-р сард Ректорын А/238 тоот тушаалаар байгуулсан бөгөөд их, дээд сургуулийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилготойгоор ажиллаж байна. Багшийн хөгжлийн төвийн дүрэмтэй.
- Тус төв нь багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, багшлах эрх олгох зэрэг багшийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн сургалтуудыг явуулдаг байна.
- Уул уурхайн технологийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар өөрсдийн мэргэжлийн чиглэлээр дотоод, гадаадын мэргэжил дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 25 багш хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Гадаадын их сургуулиудад мэргэжил дээшлүүлэхээс гадна өндөр хөгжилтэй оронд боловсролын зэрэг хамгаалсан эрдэмтэн багш нар хангалттай байгаа нь сайшаалтай.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн судалгаа болон зохиогчийн эрх нь багш нарын өөрсдийн хувийн архивт хавсаргасан байна. /нотолгоогоор /
- Эрдэм шинжилгээний дүрэм журам сургуулийн вэйб сайтад байршуулж, нотолгоогоор бүрдүүлсэн байна.
- Сүүлийн 3 жилийн байдлаар багш нар 21 ширхэг ном сурах бичиг, гарын авлага хэвлүүлж сургалтад ашиглаж байна.
- Багш нарын гадаад хэл дээр тавьсан илтгэл, нийтлүүлсэн өгүүлэл 24, дотоодод тавьсан илтгэл, нийтлүүлсэн өгүүлэл 70 ширхэг, удирдсан болон оролцсон гэрээт ажил 22 байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

• Уул уурхайн салбарын профессор, багш ажилтнуудын нээлттэй семинар, профессор багш нарын эрдэм шинжилгээний бага хурал, оюутны эрдэм шинжилгээний бага хурал жил бүр зохион байгуулж хэвшсэн нь давуу талтай байна.

Анхаарах асуудал:

• Судалгаа шинжилгээний ажлын үр дүнг хичээлийн хөтөлбөрт оруулах, үр ашгийг дээшлүүлэх, судалгааны ажлын чиглэлийг нэмэгдүүлэхэд анхаарах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын ажлын-А цаг, Багшийн эрдэм шинжилгээ инновацын ажлын Б цаг, Багшийн сургууль олон нийтийн үйлчилгээний-В цагуудыг кредитийн тооцоогоор баталгаажуулан үнэлүүлдэг байна.
- Профессор багш нар нь албан тушаалын зэрэглэлээс хамааран жил бүр 9 сард ажлын төлөвлөгөөг батлуулж, 12 болон 5 сард ажлын төлөвлөгөөг тайлагнаж, дүгнэдэг байна.
- ШУТИС-ийн “Профессор багш нарыг аттестатчилах, профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох журам”-ыг Ректорын 2013 оны 11-р сарын А/213 тоот тушаалаар батлан мөрдлөг болгон ажиллаж байна. Үнэлгээг хийхдээ багшийн өөрийн үнэлгээг төв болон салбар комиссоор хянан баталгаажуулж, оюутны үнэлгээг оролцуулан дүгнэн тогтоодог байна.
- Уул уурхайн мэргэжлийн багш болох Ижилмаа, Д.Ганзориг, Ариунжаргал, Улаанбаатар нарын эрдэм шинжилгээ судалгааны ажил, суралцагчдын хичээл бие даалтуудтай танилцаад хангалттай гэж үзэж байна. /нотлох баримт дээр тулгуурласан/
- Багшийн хавтаст: хөдөлмөрийн гэрээ, тушаал бусад байгууллагатай хамтран ажиллах гэрээ, гэрээний хүрээнд ажилласан тайлан, салбарын холбогдолтой төлөвлөгөөнүүд зэргийг нотлох баримтаар тавьсан байв.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 17 тоот тогтоолоор “Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний албыг байгуулж, ШУТИС-ийн Дотоод хяналт шалгалтын журам, ШУТИС-ийн чанарын бодлого, чанарын зорилтод хүрэх төлөвлөгөө, ШУТИС-ийн үйл ажиллагаанд чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам, ШУТИС-ийн баримт бичгийн боловсруулалт, бүртгэл, хяналтын журам зэргийг мөрдөн ажиллаж байна.
- Геологи, уул уурхайн сургууль нь чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх чиг үүргийн хүрээнд ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны гарын авлагад

зааснаар Чанарын багийг байгуулж, уурхайн технологийн салбарын үйл ажиллагааны чанарын асуудлыг Г.Уранбайгал дэд профессор хариуцан ажиллаж байна.

- Уул уурхайн ашиглалтын технологи хөтөлбөрт 2019 оны 3 сарын 19 өдөр батлагдсан сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх удирдамжийн дагуу өөрийн үнэлгээг хийж 3-р түвшинд байгааг тогтоосон байна.
- Хөтөлбөрт оролцогч талуудаас “Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар судалгаа авч, үр дүн, саналыг үндэслэн сургалтын төлөвлөгөөг 2016 онд шинэчлэн боловсруулахад Инженерийн механик, Магадлалын онол ба математик статистик, Шинжлэх ухаан технологийн англи хэл, Далд уурхайн процесс, Уурхайн хажуугийн тогтворжилт, Уурхайн төсөл, төлөвлөлт зэрэг хичээлүүдийг нэмж сайжруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ГУУС-ийн Чанарын баг нь дотоод аудитын ажлыг зохион байгуулж илэрсэн үл тохирол, анхаарах зүйл, сайжруулах санал зэргийг залруулах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.
- 2022 оноос ГУУС-ийн Чанарын баг оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааг хичээл тус бүрээр авч, холбогдох санал дүгнэлтийг хичээл зааж буй багш нарт хүргүүлэн хичээлийн хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- 2014-2018 онд явуулсан төгсөгчийн мөшгих судалгаанд 247 төгсөгч оролцосон байна.
- 2019 онд 23 ажил олгогчоос, мэргэжлийн хөтөлбөрт суралцагч 3-р ангийн 36, 4-р ангийн 16, 5-р ангийн 13, 6-р ангийн 3 оюутнаас, мөн 17 төгсөгчөөс судалгаа авсан байна.
- Ажил олгогч байгууллагууд ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль төгссөн төгсөгчийг ажилд авах сонирхол их байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт хийж ажлын төлөвлөгөөг бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулан ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Судалгаагаар тогтоогдсон сургалтын орчин, материаллаг бааз дунд зэрэг, практик дадлагыг сайжруулах, мэргэжлийн программыг эзмэшсэн байх зэрэг саналуудыг анхаарч ажиллах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Уул уурхайн ашиглалтын технологи хөтөлбөр нь БМИҮЗ-өөр 2014 онд магадлан итгэмжлүүлсэн байна.
- Магадлан итгэмжлүүлэх үед шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдлыг хүснэгтээр тусгаж өгсөн байна.
- 2014-2018 оны судалгааны үр дүнгээс харвал 481 төгсөгчөөс 62,99% нь ажил эрхэлж, 42,2% нь мэргэжлийн чиглэлээр ажиллаж байсан байна. Харин 2016, 2017 оны төгсөгчдөөс 2018-2019 онд судалгаа авахад 247 төгсөгч 100% ажилд орсон байна.
- Мэргэжлийн чиглэлээр ажил хийж буй төгсөгчдийн хувьд төгссөн жилдээ 75% нь уулын мастер болон туслах ажилтан, 25% орчим нь уулын инженер, зураг төслийн инженерээр ажиллаж байна.
- Тус мэргэжлээр төгсөгчид Австрали, Польш, Тайвань, Канад, Хятад, Япон зэрэг гадны оронд дараагийн шатанд суралцсан байна.
- Мөн 2014-2018 оны төгссөн нийт 481 төгсөгчдөөс 7-8% хувь нь гадаад болон дотоодын тэтгэлгээр дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Мэргэжлийн холбоогоор хөндлөнгөөс сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэж нягт хамтарч ажиллах.

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			

6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн “Уул уурхайн ашиглалтын технологи” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Д.Баатархүү

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Б.Бат-Очир

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Т.Цолмон

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Тайланд тусгаж харьцуулсан судалгаа хийсэн гадаадын нэр хүнд бүхий 4 улсын сургалтын төлөвлөгөөнд байгаа зарим ур чадвар олгох хичээлүүд уул уурхайн ашиглалтын технологи мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд байхгүй байгааг анхаарч, сайжруулалт хийх. • Сургалтын төлөвлөгөөнд мэргэшүүлэх хичээлийн агуулгыг ихэсгэх, үйлдвэрлэлийн дадлагын тоо, кредитийн хэмжээг нэмэгдүүлж зураг төсөл, ил уурхай, далд уурхай гэсэн чиглэлтэй болгох.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Танхимуудыг хичээлийн бус цагаар ашиглах цагийг нэмэгдүүлэх, утас, компьютер цэнэглэх газруудыг олшруулах шаардлагатай. • Далд уурхайн процесс, Далд уурхайн ашиглалтын технологи, Орд газрыг далд аргаар нээх гэсэн хичээлүүдийн лабораторийн болон компьютер загварчлалын чиглэлээр нэмэлт цагаар оюутнууд сууж ажиллах нөхцлийг бүрдүүлэх.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагаатай сургуулиудтай хамтарсан хөтөлбөрөөр суралцах оюутны тоог нэмэгдүүлэх, хөтөлбөрт гадаад оюутан ирж суралцуулахад анхаарч ажиллах • Уул уурхайн томоохон компаниудын захиалгаар мэргэжилтэн бэлтгэх, ажилчдыг мэргэжил дээшлүүлэх зориулалтаар хамтарсан хөтөлбөр боловсруулан сургалт явуулж, санхүүжилтийн эх үүсвэрийн нэмэгдүүлэх
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн ашиглалтын технологи мэргэжлээр төгсөгчдийн эрэлт хэрэгцээ их байгаатай уялдуулж элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, хөтөлбөрийн сурталчилгааг сайжруулах • Компаниудын гэрээгээр тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцагчдын тоог нэмэгдүүлэх • Мэргэжлээс шилжин суралцагчдын шалтгааныг судлан багасгах боломжийн талаар арга хэмжээ төлөвлөн ажиллах
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрт мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Эрдмийн цол, зэрэг	Ажиллаж байгаа албан тушаал	Ажилласан жил	Заах боломжтой хичээл
1	Б.Ганзориг	Доктор (Ph.D)	Салбарын эрхлэгч	19 жил	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн удиртгал 2. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 3. Ил уурхайн процесс I, II 4. Уурхайн төсөл, төлөвлөлт 5. Ил уурхайн ашиглалтын технологи I 6. Ил уурхайн төсөл 7. Уурхайн хажуугийн тогтворжилт 8. Уурхайн усан хангамж
2	Ц.Ариунжаргал	Доктор (Ph.D)	Ахлах багш	13 жил	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн удиртгал 2. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 3. Чулуулгийн физик 4. Чулуулгийн бутлалт 5. Уурхайн төсөл, төлөвлөлт
3	Ж.Ижилмаа	Магистр	Ахлах багш	18 жил	<ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 2. Уурхайн малталт нэвтрэлт, бэхэлгээ 3. Далд уурхайн процесс 4. Далд уурхайн ашиглалтын технологи I 5. Далд уурхайн төсөл 6. Уурхайн агааржуулалт
4	М.Дагва	Магистр	Ахлах багш	22 жил	<ol style="list-style-type: none"> 1. Ил уурхайн ашиглалтын технологи I, 2. Шороон болон түгээмэл тархацтай ордын ашиглалт 3. Уулын ажлын оновчлол
5	Б.Улаанбаатар	Магистр	Багш	14 жил	<ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 2. Ил уурхайн процесс I, II 3. Уурхайн орчин, нөхөн сэргээлт 4. Уурхайн төсөл, төлөвлөлт 5. Уурхайн хажуугийн тогтворжилт
6	Ө.Ган-Од	Магистр	Багш	13 жил	<ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 2. Ил уурхайн процесс I, II 3. Ил уурхайн ашиглалтын технологи I 4. Уурхайн төсөл, төлөвлөлт
7	Б.Тамир	Магистр	Багш	11 жил	<ol style="list-style-type: none"> 1. Уурхайн малталт нэвтрэлт, бэхэлгээ 2. Далд уурхайн процесс 3. Далд уурхайн ашиглалтын технологи I 4. Далд уурхайн төсөл 5. Уурхайн агааржуулалт

8	Г.Амартүвшин	Магистр	Багш	11 жил	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн удиртгал 2. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 3. Чулуулгийн физик 4. Чулуулгийн бутлалт 5. Ил уурхайн процесс I, II 6. Уулын ажлын оновчлол 7. Уурхайн төсөл, төлөвлөлт
9	Х.Мөнхнасан	Магистр	Багш	10 жил	<ol style="list-style-type: none"> 1. Ил уурхайн ашиглалтын технологи I 2. Уурхайн төсөл, төлөвлөлт 3. Уулын ажлын оновчлол 4. Ил уурхайн төсөл
10	Д.Ганзориг	Магистр	Багш	7 жил	<ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 2. Ил уурхайн ашиглалтын технологи I 3. Уурхайн төсөл, төлөвлөлт 4. Уулын ажлын оновчлол
11	А.Нямтулга	Магистр	Дадлагажигч багш	6 жил	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн удиртгал 2. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс 3. Уурхайн аюулгүй ажиллагаа 4. Шороон болон түгээмэл тархацтай ордын ашиглалт

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Мөнхтулга	УУАТ, 1-р курс	Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг	80740309
2	Мишээл	УУАТ, 1-р курс	Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг	99363207
3	Лхамсүрэн	УУАТ, 1-р курс	Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг	99363207
4	Сумъяа	УУАТ, 1-р курс	Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг	99759323
5	Энхбат	УУАТ, 1-р курс	Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг	85140942
6	Э.Хулан	УУАТ, 2-р курс	Улаанбаатар	88645406
7	Б.Одхүү	УУАТ, 2-р курс	Орон нутгийн, айлд	85877069
8	Б.Анужин	УУАТ, 2-р курс	Орон нутгийн, Байр түрээс	95521028
9	П.Буяннэмэх	УУАТ, 2-р курс	Орон нутгийн, айлд	86173651
10	А.Төгөлдөр	УУАТ, 2-р курс	Орон нутгийн, айлд	99553962
11	Б.Золбаяр	УУАТ, 3-р курс	Гадуур	99347443
12	С.Мусауир	УУАТ, 3-р курс	Гадуур	94702275
13	М.Идэрбат	УУАТ, 3-р курс	Оюутны байр	99381848
14	С.Баттэмүүлэн	УУАТ, 4-р курс	Орон нутгийн оюутан	
15	А.Отгонбат	УУАТ, 4-р курс	Орон нутгийн оюутан	
16	Б.Мөнхбаяр	УУАТ, 4-р курс	Сайн дурын үйлд ажиллагаанд идэвхитэй оролцдог	
17	Б.Ууганбаатар	УУАТ, 4-р курс	Орон нутгийн оюутан	

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
18	А.Бүрэнбаатар	УУАТ, 4-р курс	Голч дүн	
19	Ш.Насанбуян	УУАТ, 4-р курс	Орон нутгийн оюутан	
20	Ц.Одхүү	УУАТ, 4-р курс	Голч дүн	
21	М.Нямзаяа	УУАТ, 4-р курс	Орон нутгийн оюутан	
22	Ц.Тэнгисболд	УУАТ, 4-р курс	Орон нутгийн оюутан	
23	М.Мөнхбат	УУАТ, 4-р курс	Сайн дурын үйлд ажиллагаанд идэвхитэй оролцдог	

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Д.Дамба	УУХҮЯам,	ахлах шинжээч
2	П.Түвшинжаргал	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ,	ерөнхий уурхайчин
3	Д.Уужимсанаа	Эрдэнэс тавантолгой ХК,	уул уурхайн хэлтсийн дарга
4	С.Эрдэнэбилэг	Энержи ресурс ХХК,	ерөнхий инженер
5	Г.Идэр	Оюутолгой ХХК,	ахлах инженер
6	Б.Мөнхбат	Бласт эксперт инженеринг ХХК,	захирал
7	Түмэн-Од	Гоулдмэн прожект ХХК,	захирал
8	Зоригт-Эрдэнэ	Болдтөмөр Ерөө Гол ХХК,	ерөнхий инженер
9	Хишигбаатар	МММаркет ХХК,	захирал
10	Цэвэгмид	Айл баян урхай	дарга
11	Тэгшбуян	Мера сервис ХХК,	гүйцэтгэх захирал

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Багдаулет	2017	Оюутолгой ХХК	
2	Ч.Мөнх-Оргил	2017	Эрдэнэс тавантолгой ХК	
3	Мөнх-Эрдэнэ	2018	Рэдпаф монгол ХХК	тэсэлгээний инженер
4	Галт	2018	Рэдпаф монгол ХХК	тэсэлгээний инженер
5	Ц.Ариунболд	2019	Оюутолгой ХХК	
6	Ганчигноров	2019	Эмералд инженеринг ХХК	
7	Нямсамбуу	2019	Эмералд инженеринг ХХК	
8	Буянхишиг	2020	Хишиг Арвин ХХК Сор говь төсөл	уулын мастер
9	Х.Баттүшиг	2021	Арга Оч ХХК	зураг төслийн инженер
10	Насанжаргал	2021	Цариг ресурс	зураг төслийн инженер
11	Азжаргал	2022	Баянголын төмрийн хүдрийн уурхай	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ
14191, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 34,
Утас/Факс: (976-11) 51 22 91, И-мэйл: guus.info@must.edu.mn,
Вэбсайт: www.guus.edu.mn

2022. 11. 21 № 357

тантай _____ -ны № _____ -т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Уул уурхайн ашиглалтын технологи (D072401) хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт хүргүүлэн холбогдох тайланг хүргүүлэн өгсний дүнд тантай байгууллагаас шинжээчийн баг томилогдон тус сургуульд дээр ажилласан. Шинжээчийн багийн 2022 оны 11-р сарын 07-ны өдрийн урьдчилсан тайлантай танилцан зөвшөөрч байгаагаа энэхүү албан бичгээр хүргүүлж байна.

ЗАХИРАЛ



К. ХАВАЛБОЛОТ

367770556

Act
Go t